



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/149

Мөрөн сум

Цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг  
хүчингүй болгож, тусгай зөвшөөрөл  
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.3, 30.1.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Даян Саян-Индиго” хүүхдийн цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг 2022 оны 05 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүйд тооцугай.

2. “Даян Саян” хязгаарлагдмал хариуцлагатай компанид сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 05 дугаар сарын 1-ний өдрөөс 2027 оны 05 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай.

3. Тус компанид сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгон баталгаажуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/67 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Ганбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН